0-5 НАСНЫ ХҮҮХДИЙН АХУЙН ОСОЛ ГЭМТЭЛД ӨРТӨХ ЭРСДЛИЙГ ТОДОРХОЙЛСОН ДҮН

А.Аюурзана[2], Ж. Гэрэлмаа[1], М. Мөнхчимэг[1], Д. Пүрвээ[1], Батжаргал[1], Ц.Цэрэндолгор[1], Н.Мягмарсүрэн[1], Т.Жаргал[1], , Б.Туяажаргал[2], А.Цолмонтуяа[2], Б.Батхүү[2]

[1] "Шэжид Дүг" ӨЭМТ
[2] АШУҮИС-АУС, ӨАУ-ны тэнхим
ayurzana@mnums.edu.mn

Түлхүүр үг:

Хүүхдийн осол гэмтэл, халуун тогоо, зөөлөн тоглоом, асран хамгаалагч

Товч утга: Үндэслэл: Хүүхдийн осол гэмтэл эрүүл мэндийн чухал асуудал бөгөөд амь эрсдэхээс бүрэн сэргийлэх боломжтойгоос гадна удаан хугацааны дараа үүсэх хөгжлийн бэрхшээлээс сэргийлэх боломжтой юм. Энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажил хомс байгаа нь уг ажлыг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Хүүхдийн ахуй осол гэмтэлд өртөх эрсдлийн түвшин болон эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох. **Судалгааны ажлын арга, аргачлал:** 0-5 насны 400 оролцогчийг судалгаандаа хамруулж, чанарын аргаар дүн шинжилгээг хийж гүйцэтгэлээ. **Үр дүн:** Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 40% нь хоолоо дан халуун тогоонд, 25% нь зууханд, 15% нь плитканд, 7.5% (P>0.05) нь газаар, 4% (P>0.05) нь зуух ба плитка мөн 4% (P>0.05) нь халуун тогоо, гааз, зуух харин 2.5% (P>0.05) нь халуун тогоо ба зуух ашиглан хоолоо хийдэг гэж хариулжээ. Гэрийн нөхцөлд хүүхдийн унтаж байгаа ор хэтэрхий байгаа бөгөөд хүүхдэд зориулсан зөөлөн тоглоомын талаар эцэг эхчүүдийн ойлголтыг үнэлэхэд 45.5% (P>0.05) нь хэмжээ нь хэтэрхий жижиг биш бол ариутгал цэвэрлэгээ хийсэн тохиолдолд аюулгүй гэж дүгнэжээ, 9.1% нь жижиг хэсгийг нь салгаад амандаа хийх аюултай, 36.4% (P>0.05) нь осолтой гэж бодохгүй байна гэсэн бол 9% (P>0.05) нь огт хариулаагүй байна. **Дүгнэлт:** Түлэгдэх болон өндрөөс унах эрсдлийн түвшин хамгийн өндөр байна. Зөөлөн тоглоомын хүүхдэд үзүүлэх эрсдэлийн талаарх мэдээлэл эцэг эхчүүдэд хангалтгүй байна, хүүхдийн унтаж байгаа орны өндөр их байгаа унах эрсдлийг дагуулж байна.

Үндэслэл: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хүүхдийг осол гэмтлийн эрсдлээс урьдчилан сэргийлж чадвал өдөрт 2000 гаруй хүүхдийн амь нас, эрүүл мэндийг аврах боломжтойг мэдээлж байна. АНУ-ийн Аюулгүй Байдлын төвөөс гаргасан мэдээллээс жилд 12000 хүүхэд осол гэмтэлд өртөж байна[1]. Африкийн орнуудад хүүхдийн осол гэмтэл 100,000 хүнд амд 17,4% буюу хамгийн өндөр, 2-р байранд Газрын дундад дундад тэнгисийн орнууд тус тус эзэлдэг байна[1]. Судалгаагаар хүүхдийн осол гэмтлийн 90 гаруй хувь нь асран хамгаалагч, эцэг эхийн хайхрамжгүй байдлаас үүдэлтэй ба хүүхдийн осол гэмтлийн улмаас нас барах тохиолдол хөгжил буурай оронд 3,4 дахин их байна[1]. Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 9 буюу 1.8 хувь нь, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 38 буюу 36.5 хувийг осол гэмтлийн шалтгаант эндэгдэл эзэлж байна[2]. Засгийн газрын 2018 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн 3.1.3.2.-д заасны дагуу мөн хүүхдийн ахуйн осол гэмтлийн тохиолдол өндөр байгаа нь уг судалгааны ажлыг хийх үндэслэл боллоо.

Зорилго: 0-5 насны хүүхдийн ахуйн эрсдлийн түвшин болон эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох .

Зорилт:

1. 0-5 насны хүүхэд гэртээ ахуйн осол гэмтэлд өртөж болзошгүй эрсдлийн түвшинг үнэлэх
2. Ахуйн зарим эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох

Судалгааны арга аргачлал:
ЧД 12-р хорооны 0-5 насны хүүхэдтэй 400 оролцогчийг хамруулна. Судалгаанд тоон судалгааны аргаар Microsoft Excel 2010 программуудыг ашиглан график дүрслэл, хүснэгт хийж статистик боловсруулалтыг хийлээ.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 75% нь 0-5 насны хүүхэд нь өмнө осол гэмтэлд өртсөн байсан бол үлдсэн 25% нь осол гэмтэлд өртөөгүй байна. Харин гэрийн нөхцөлд хүүхдэд аюултай зүйлсийг хүүхдээс хол гар нь хүрэхгүй болон хүүхэд авч чадахгүй газарт байрлуулдаг эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдагсдын 62,5% тийм гэсэн бол 35% үгүй, 2,5% нь мэдэхгүй гэж хариулжээ. Сүүлийн

жилүүдэд гэрийн нөхцөлд бага насны хүүхдүүд осол гэмтэлд өртсөн тохиолдлуудын дийлэнх нь халуун тогоонд түлэгдсэн статистик мэдээллүүд байсан үүнийг тодруулах зорилгоор асуусан 3-5 дугаар асуултын үр дүнд нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 40% (P>0.05) нь хоолоо дан халуун тогоонд, 25% (P>0.05) нь зууханд, 15% (P>0.05) нь плитканд, 7.5% (P>0.05) нь газаар, 4% (P>0.05) нь зуух ба плитка мөн 4% (P>0.05) нь халуун тогоо ,гааз, зуух харин 2.5% (P>0.05) халуун тогоо ба зуух ашиглан хоолоо хийдэг гэсэн бол халуун тогоо ашиглан хоол хийхдээ газарт шалан дээр тавьж хийдэг байдлыг тодруулахад 32% (P>0.05) нь тийм гэсэн бол 60% нь үгүй, 3% нь мэдэхгүй, 5% нь огт энэ асуултанд хариулаагүй байна. Харин 5-р асуулт болох зуух янданд хүүхэд хүрэхээс сэргийлсэн тор таславч байгаа эсэхийг тодруулахад 280 хүн буюу судалгаанд хамрагдагсдын 70% (P>0.05) нь байхгүй гэсэн бол 90 хүн буюу 22.5% (P>0.05) нь байгаа 20 буюу 5% (P>0.05) нь мэдэхгүй 10 буюу 2.5% нь энэ асуултанд огт хариулаагүй байна. Гэрийн нөхцөлд хүүхэд осол гэмтэл авч болох бусад зүйлсийг тодруулахаар асуусан асуултаас хамгийн эрсдэлтэй нь хүүхдийн унтаж байгаа ор нь хүүхэд унавал бэртэж гэмтэхээр өндөр болох нь харагдлаа. Хүүхдэд зориулсан зөөлөн тоглоомын талаар эцэг эхчүүдийн ойлголтыг үнэлэхэд 45.5% (P>0.05) нь хэмжээ нь хэтэрхий жижиг биш бол ариутгал цэвэрлэгээ хийсэн тохиолдолд аюулгүй гэж дүгнэжээ, 9.1% (P>0.05) нь жижиг хэсгийг нь салгаад амандаа хийх аюултай, 36.4% нь осолтой гэж бодохгүй байна гэсэн бол 9% (P>0.05) нь огт хариулаагүй байна.

Хэлцэмж: Осол гэмтлийн эзлэх хувиар буурай хөгжилтэй улс орнууд тэргүүлж байдаг бөгөөд Африкийн улс орнуудад болон Газрын дундад тэнгисийн улс орнуудад хүүхдийн осол гэмтэл тэргүүлж байна[4]. Осол гэмтлийн тоон үзүүлэлтээр хамгийн бага байгаа улс оронд Британи, Герман, Нидерланд тус тус эзэлж байгаа бөгөөд эдгээр оронд усанд живэх, авто замын ослын тохиолдол хамгийн их бүртгэгдсэн бол манай улсанд түлэгдэл (халуун тогооны) их байна [1,4-5].

Дүгнэлт:

1. Түлэгдэх болон өндрөөс унах эрсдлийн түвшин хамгийн өндөр байна.
2. Зөөлөн тоглоомын хүүхдэд үзүүлэх эрсдэлийн талаарх мэдээлэл эцэг эхчүүдэд хангалтгүй байна, хүүхдийн унтаж байгаа орны өндөр их байгаа нь унах эрсдлийг дагуулж байна.

Ном зүй:

1. *Ц.Мөнхнасан "0-5 насны хүүхдийн ахуйн осол гэмтэлд өртөх эрсдлийг үнэлэх нь", 2015*
2. *Нийслэлийн эрүүл мэндийн газар "Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт", 2017*
3. *Засгийн газрын 2018 оны 163 дугаар тогтоолоор батлсан "осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр"*
4. *Harker P, Moore L. Primary health care action to reduce home accidents: a review. Health Education Journal 1996;53:322–31.*
5. *Wolley A. The risk pack: a teacher's resource to help children assess and manage risk. London: Child Accident Prevention Trust, 1996.*

DETERMINING THE RISK OF DOMESTIC ACCIDENTS INJURIES FOR CHILDREN AGED FROM 0-5 YEARS OLD

A.Ayurzana [2]G.Gerelmaa[1], [2] M.Monkchimeg[1], D.Purvee[1], N.Batjargal[1], Ts.Tserendolgor[1], N.Myagmarsuren[1], T.Jargal[1], B.Tuyajargal[2], A.Tsolmontuya[2], B.Batkhuu[2]

[1]"Shejid Dug" Family Health Center
[2]Department of Family Medicine,School of Medicine, MNUMS, ayurzana@mnums.edu.mn

Introduction: Accidents to children are a significant health issue, being a major cause of preventable death, serious injury and long-term disability across the Mongolia. Lack of research study in terms of the children accident and therefore it was raised to conduct the research study

Objectives*:* To examine children's accounts of injury risks as well as the domestic risks

Methods: 400 respondents were held with 0–5 year old children. Transcripts of the discussions were analyzed using qualitative methods.

Results: 40% of the respondents were cooked in a single hot pot, 25% in an oven, 15% on a stove, 7.5% (P> 0.05 with gas, 4% (P> 0.05) blast furnace and cookstove, and 4% (P> 0.05) hot pot, gas, and blast furnace, 2.5% (P> 0.05) answered that they cook using hot pots and stoves. Assessing parents perceptions of soft toys for children in the home, 45.5% (P> 0.05) concluded that it is safe to sterilize if the size is not too small, 9.1% said it was dangerous to remove a small piece and put it in their mouth, 36.4% (P> 0.05) did not think it was dangerous, and 9% (P> 0.05) did not answer at all.

Conclusions*:* According to the survey, the risk of burns and falls was the highest. Lack of information about the risks of soft toys for children, height of bed is tall which leading with the high risk.

Key words: Child accident, boiling pan, soft toys, care givers